

МОНГОЛБАНКНЫ ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛӨӨС ШИЙДВЭР ГАРГАВ.

Монголбанкны Хяналтын зөвлөлийн ээлжит хурал 2010 оны 9 дүгээр сарын 28-ны өдөр болж, энэ оны ажлын төлөвлөгөөнд тусгагдсан хэд хэдэн асуудлыг хэлэлцэж шийдвэр гаргасан байна. Тухайлбал, Хяналтын зөвлөлийн хурлаар Монголбанкны 2009 оны санхүүгийн тайланд аудитын компаниас өгсөн зөвлөмж, түүний хэрэгжилтийн байдал, Монголбанкнаас УИХ, олон нийтэд өгөх мэдээллийн чанар, үр нөлөө, цаашид авах арга хэмжээ болон Монголбанкны авлага барагдуулах ажлын явц, үр дүнгийн талаарх мэдээллийг тус тус хэлэлцээд Монголбанкны удирдлагад доорх зөвлөмжийг хүргүүлсэн байна. Үүнд:

1. Монголбанкны дотоод хяналтын ажил нь нэг хэвийн шинж чанартай, асуудалд тодорхой судалгаа дүгнэлт хийдэггүй, илэрсэн зөрчил дутагдлыг арилгах арга замыг заадаггүй, өнгөц байдалтай хийгдэж байгааг тэмдэглэж, дотоод хяналтын ажлын зохион байгуулалт, арга зүйг боловсронгуй болгох, ажилтнуудын мэдлэг боловсролыг дээшлүүлэх, гүйцэтгэлийн хяналтыг хүчтэй болгох талаар тодорхой арга хэмжээ авч, үр дүнг 2011 оны 7 сард багтаан Хяналтын зөвлөлд тайлагнахыг Дотоод аудитын газарт үүрэг болгох;

2. Төв банк / Монголбанк/-ны тухай хуулийн 23 дугаар зүйлийг удаа дараалан зөрчсөн үйлдлийн улмаас үүссэн алт олборлогч Монгол газар, Эрдэс, Монполимет, Хайлааст компаниудаас авах 27,7 тэрбум төгрөгийн авлагыг даруй авах талаар хугацаатай, бодитой арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

3. Монголбанк эрхийг нь хүлээн авсан Зоос, Анод банкинд олгосон 2009 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 127,6 тэрбум төгрөгийн тооцооны асуудлыг шийдвэрлүүлэх талаар тодорхой санал боловсруулж Засгийн газарт оруулах;

4. Аудитын компаниас Удирдлагын захидалд өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж, дүнг 2011 оны эхний улиралд Хяналтын зөвлөлд тайлагнах;

5. Монголбанкнаас УИХ, олон нийтэд хүргэх мэдээллийн чанар, үр нөлөөг сайжруулах талаар хийх ажлаа эрчимжүүлэх;

6. Монголбанкинд үүссэн өр авлагыг илэрсэн огноо, мөнгөн дүн, хариуцах эзэн, авлагыг барагдуулж байгаа албан тушаалтан, барагдуулахад гаргасан зардал, авлага барагдуулахад гарсан ахиц өөрчлөлтийг мөнгөн дүнгээр илэрхийлсэн тайлан гаргаж улирал бүр Хяналтын зөвлөлд ирүүлэх зэрэг болно.

МОНГОЛБАНКНЫ ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛ